

**БОГД БАНКНЫ ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ 2021 ОНЫ
СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН**

Миний бие Богд Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн болон ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Хүний нөөцийн хорооны даргаар томилогдон ажиллаж байна.

Хүний нөөцийн хороо нь 2021 оны 8 сар болон 12-р сард тус тус хуралдаж Гүйцэтгэх захирлын 2021 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, ТУЗ-ийн гишүүдийн тоог нэмэгдүүлэх талаар хэлэлцэж, саналаа өгч хуралд оролцсон байна.

Тайлант хугацаанд Аудитын хороог 4 удаа хуралдуулж, аудитын тайлан болон бусад асуудлыг хэлэлцсэн. Дотоод аудитын газраас бэлтгэсэн аудитын тайлан, дүгнэлттэй тухай бүр танилцаж, чиглэл өгч ажилласан.

Хорооны хурлуудад зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлөөгүй, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцэж ажилласан.

2021 оны 2-р хагас жилд ТУЗ-өөс зарлагдсан бүх хуралд зайнаас оролцон саналаа өгч ТУЗ-ийн хараат бус гишүүний үүргээ 100% биелүүлж идэвхтэй ажилласан болно.

БОГД Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн

Ж.Нарантуяа